


2015.3 Дугаар 10

 **Монгол дахь төлөөлөгчийн газарт шинээр томилогдон ажиллаж буй орлогч дарга Савада Хироми**

 **Project E-News**


[Гүүрийн засвар арчлалтын чадавхийг сайжруулах төсөл]

Хөтөлбөрийн ажилтан Ц. Хоролсүрэн

 **Volunteer E-News**

[Савада Юүри сайн дурын гишүүний тухай]

Сайн дурынхныг хариуцсан ажилтан Ц. Орхонтуяа

 **Сургалт төгсөгчдийн булан**

[Сургалтын дараах үйл ажиллагаа]

**Эрүүл мэндийн асуудал хариуцсан дэд сайд,
Жайка сургалт төгсөгчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн Д.Атармаа**

Бэлтгэсэн : Х. Түвшин-Од



Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Намайг Савада Хироми гэдэг. Миний бие Жайка-ийн төвийн дэлхийн байгаль орчны газар ажиллаж байгаад энэ жилийн 1 сарын 4-нээс тус төлөөлөгчийн газрын орлогч даргаар томилогдож ирсэн. Өнөөг хүртэл Жайка-ийн байгаль орчны хэлтэс, газарт усны нөөцийн төсөл хөтөлбөр, мөн байгууллагын төсөв, хүний нөөцийн асуудлыг хариуцан ажиллаж байсан.

Энд томилогдож ирэх хүртлээ Монгол оронтой холбоотой ажил гэвэл буцалтгүй тусламжийн хамтын ажиллагааг хариуцаж байхдаа Дархан болон Улаанбаатарын ус сувгийн газартай хамтран хэрэгжүүлсэн төслийг хариуцан ажиллаж байлаа. Тухайн үед Монголд томилолтоор ирэх боломж олдоогүй бөгөөд анх удаа Монголд ирж байна. Дархан, Улаанбаатар хотын ус сувгийн газар хэвийн ажиллаж байгаа гэдэгт найдаж байна.

Хамгийн хүйтэн улиралд томилогдон ирэх болсон тул Японоос ирэхдээ дулаан хувцас, гутал, кайро (гартаа атгадаг, халуунаа барьдаг элс) их хэмжээгээр бэлдсэн боловч төсөөлснөөс дулаахан байсан ба энэ жил өнтэй өвөл болсон учир авчирсан кайроогоо нэгийг ч хэрэглэсэнгүй өвлийг давж байна. Монголд ирээд нүд ирмэх зуур 2 сар өнгөрөн, сүүлийн үед гадаа нэмэх градустай урин дулаан болж, хаврын уур амьсгал ороод бүр сайхан байна.

Жайка-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар 30 гаруй ажилтантай, 50 гаруй төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байна. Цаашид 3 жил орчим Монголд ажиллахдаа Төлөөлөгчийн газрыг тогтвортой удирдлагаар хангаж ажиллах мөн төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэхээр зорьж ажиллана. Ажлынхаа хажуугаар Монголын соёл заншил, үзэсгэлэнт байгальтай танилцах боломжийг мөн алдахгүй гэж бодож байна.

Та бүхний хамтын ажиллагаанд талархал илэрхийлье.

Гүүрийн засвар арчлалтын чадавхийг хөгжүүлэх төсөл

Төслийн товч агуулга

Хугацаа: 2013 оны 8 сараас 2015 оны 9 сар хүртэл

Нийт төсөв: 200 сая иен

Гол хөрөнгө оруулалт: Мэргэжилтэн илгээх, Япон дахь сургалт

Монгол талын хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Нийслэлийн автозамын газар, Авто замын газар

Төслийн эрхэм зорилго:

Монгол улсын гүүрийн засвар арчилгааны чадавхи сайжирна.

Төслийн зорилго:

Авто замын газар болон Нийслэлийн авто замын газрын ажилтнуудын гүүрийн засвар арчилгааны ажлын төлөвлөгөөний чадавхи сайжирна.

Үр дүн:

1. Гүүрний засвар арчлалтын цикл” гэсэн ухагдахууныг өргөн хүрээнд ойлгож, хяналт шалгалт, үнэлгээ, тэргүүлэх ач холбогдлын эрэмбэлэлт, арга хэмжээний сонголттой холбоотой зааварчилгаа, гарын авлага боловсруулна.
2. Гүүрний талаарх мэдээлэл бүртгэх мэдээллийн санг байгуулна.
3. Гүүрний засвар арчлалтын бодлого, хөтөлбөр боловсруулах.
4. ЗТЯ болон НЗДТГ-ын гүүр/хийцийн засвар арчлалт, менежменттэй холбоотой ажилтнуудыг сургалтанд хамруулах, Монголын талаас сургалт зохион байгуулах

Монгол улс 2007 оны байдлаар ойролцоогоор 49,186 км замын сүлжээтэй бөгөөд ЗТЯ нь улсын нийт замын 11,136 км зам, 375 ширхэг гүүрийн барилга, үйл ажиллагаа, менежментийн хөгжлийг хариуцан ажиллаж, НЗДТГ нь 460 км зам, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод байрлах 67 гүүрийг хариуцдаг.

Монгол улсын ихэнхи гүүр 1960-аад оноос хойш ЗХУ болон БНХАУ-ын тусламжаар баригдсан бөгөөд хуучирч муудан, замын хөдөлгөөний ачаалал даахгүй болсон тул улам бүр нэмэгдэж буй замын хөдөлгөөний ачаалалд тохируулан тэдгээрийг дахин сэргээн засварлах, шинэчлэх шаардлага гарч байна. Гэвч төсвийн хязгаарлагдмал байдал болон инженерийн боловсон хүчин дутагдалтайгаас 1990 оны ардчилсан хувьсгалаас хойш зам засварын хангалттай ажил хийгдээгүй юм.

Мөн зарим зам засварын компаниудтай гэрээ байгуулж зам, гүүрийн засварын ажлыг

хэрэгжүүлсэн боловч тэдгээр нь багахан хэмжээний засвар, яаралтай нөхөн сэргээх ажлаас хэтрээгүй бөгөөд мэргэжлийн судалгаа шинжилгээнд үндэслээгүй, тохиромжтой бодлого, төлөвлөлт, засвар арчлалт менежментийн системгүй байсан юм.

Төслийн сүүлийн үеийн мэдээ:

Монгол улсын гүүрийн насжилт болон сүүлийн жилүүдийн эдийн засгийн өсөлтөөс үүдэлтэй замын хөдөлгөөний эрчимтэй өсөлт, даац хэтрүүлсэн автомашины хөдөлгөөнөөс хамаарч, гүүрнүүдийн эвдрэл гэмтэл ихэсч байна.

Энэ байдал үргэлжилсээр байвал гүүрийн нуралт, зорчих боломжгүй болох зэрэг Монгол улсын эдийн засагт багагүй хэмжээгээр муугаар нөлөөлж болзошгүй тул эдгээр гүүрнүүдэд анагаах ухаанаар зүйрлэвэл тохиромжтой оношлогоо, эмчилгээний картанд үндэслэсэн төлөвлөгөөт эмчилгээ нэн шаардлагатай байна.

Өнөөдрийг хүртэл Япон улсын зүгээс “Нарны гүүр” зэрэг гүүрийн бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлж ирсэн ба энэхүү төслийн хүрээнд гүүрийн үзлэг, гүүрийн ашиглалтын түвшний үнэлгээ, гүүрийн засвар, хүчитгэлийн ажлын аргыг сонгох гэсэн 3 төрлийн гарын авлагыг боловсруулан гаргах, гүүрийн мэдээллийн санг үүсгэх, засвар арчлалтын тохиромжтой төлөвлөгөөг боловсруулан гаргах тал дээр тус бүр Монгол талын холбогдох хүмүүстэй хамтран ажиллаж, төслийн нэгжийн хурал болон семинар, газар дээрх сургалтаар дамжуулан засвар арчлалтын чадавхийг хөгжүүлэхээр зорьж байна.

Цаашид энэхүү төсөлд Монгол талаас хамтран ажилласан хүмүүс маань “Сургагч-Багш”-ийн хувиар өөрийн олж авсан мэдлэг, технологио харьяалагдах байгууллага дотроо төдийгүй замын засвар арчлалтын компани зэрэг холбогдох байгууллагуудад өргөнөөр нэвтрүүлэн ажиллахаар төлөвлөж байна.



Жайка Монгол дахь Төлөөлөгчийн Газарын хөтөлбөрийн ажилтан Ц. Хоролсүрэн

Сайн байна уу эрхэм хүндэт залуусаа! Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Ингээд энэ удаагийн дугаарт Дорноговь аймгийн Сайншандын Нэгдсэн эмнэлэгт сувилагчаар 2 жилийн хугацаатай ажиллаад буцсан Савада Юрий сайн дурын гишүүний ажлын талаар товч танилцуулъя.

Савада Юрий 2013 оны 1 сараас 2 жилийн хугацаатай Сайншандын Нэгдсэн эмнэлэгт ажиллахдаа тус эмнэлэгийн мэс засал, эрчимт эмчилгээ, яаралтай түргэн тусламжийн тасгуудын сувилагч нарт асаргаа сувилгааны шинэ арга технологийг танилцуулан нэвтрүүлж ажилласан. Тэрээр ажиллах хугацаандаа тасаг бүрт сургалт зохион байгуулж, сургалтаар өгсөн мэдлэгийг дадлагаар баталгаажуулж, асаргаа сувилгаа хийхэд дөхөм болхуйц шинэ санааг дэвшүүлж, тасгийн сувилагч нартай хамтран сувилгааны ажилд хэрэгтэй жижиг хэрэглэгдэхүүнийг гарын доорхи материал ашиглан хийх гэх мэт олон ажлыг хийсэн байна.

Мөн Монгол улсын хуулийн дагуу иргэн хүн эмнэлэгт нэг удаа хэвтэн эмчлүүлэх хугацаа 10 хоног байдагтай холбоотойгоор хүнд өвчтэй хүмүүс эмнэлгээс гараад шууд ар гэрийн асаргаанд шилждэг учраас гэрийн асаргаа сувилгаа болон хавдартай өвчтөнүүдэд хөнгөвчлөх эмчилгээ хийх туршлагаа хуваалцаж, эмнэлгийн сувилагч нартай хамтран өрх гэрүүдээр явж, сургалт сувилгаа хийсэн нь ард иргэдээс ихээхэн талархал хүлээсэн.

Энд онцолж хэлэх нэгэн шинэ санаа бол Монгол улсын хөдөө орон нутагт том хүн болон хүүхдийн түлэгдэлт их байгааг анзаарч түлэгдэлтийн үед



хийдэг эмчилгээний шинэ аргыг нэвтрүүлсэн явдал юм. Одоо манай улсад хийж буй эмчилгээний арга нь эдгэрэлт удаан, өвчтөнд зовиуртай, зардал ихтэй байгаа тул Япон улсад нэвтрээд удаагүй ч эмчилгээний үр дүн өндөр нэгэн аргыг зориг гарган нэвтрүүлсэн юм. Мэдээж маш олон жил хийгдсэн аргыг шууд өөрчлөх нь боломжгүй тул 1 жил 8 сарын турш тухайн аргыг туршиж хэрхэн өөрчлөгдөж буй процессыг ажиглан зургаар баримтжууланы үндсэн дээр тухайн эмнэлгийн мэс

заслын бүх эмч сувилагч нарт танилцуулсанаар тэд ч энэ аргыг нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзсэний дүнд одоо уг аргыг Сайншандын нэгдсэн эмнэлэгт ашиглаж байна.

Өнөөг хүртэл түлэгдэлтийг эмчлэхдээ хатаах аргыг голчлон ашиглаж байгаа бол Савада сайн дурын гишүүний нэвтрүүлсэн шинэ арга нь аль болох хатаахгүй чийглэг байлгах эмчилгээний арга юм. Энэ аргыг ашигласанаар 10 хоног хэвтэн эмчлүүлдэг байсан хугацаа 2 хоног болон цөөрч, өвчтөнд зовиур багатай, сорви үлдэхгүй, эдийн засгийн хувьд хэмнэлттэй энгийн гялгар уут, вазелин гэх мэт гарын доорхи материалаар эмчилгээг хийж болох олон талын ашигтай арга

Эмчилгээний үр дүн



Боосон марлигаар чийглэх эмчилгээг эхэлсэн. Өдөр бүр Буцалсан бүлэн усаар цэвэрлэж галгар уутгаар бооно. Халдваргүйжүүлэх уусмалаар ариутгаггүй.

Чийглэх эмчилгээ хийж эхэлсэн өдрийн оройноос нь уйлахаа болисон. Хоолны дуршил сэргэж эхэлсэн.



6 хоногийн дараа, амбулаторид



Чийглэх эмчилгээ үргэлжилж байна. Зөөлөрсөн тавыг амбулаторид тайрч авахад доороос нь эрүүл арьс гарч ирж байна. Өвдөлтгүй.



ЮМ.



Эмнэлгээс гараад хагас жил болсон. Сайхан эдгэсэн гоё байгаа биз.

Иймд уг аргыг олон эмнэлэг туршиж үзэн нэвтрүүлбэл түлэгдэлтээс болж олон сар зовж буй хүмүүст хэрэг болох болов уу гэдэг үүднээс та бүхэнд танилцууллаа.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай.

Жайка Монгол дахь Төлөөлөгчийн Газарын хөтөлбөрийн ажилтан Ц. Орхонтуяа



Эрүүл мэндийн асуудал хариуцсан дэд сайд Жайка-ийн сургалт төгсөгчдийн Монголын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, 2011 оны сургалтанд оролцогч, Д. Атармаа Сургалтын нэр: Pneumoconiosis and Asbestos-related Disease

Би хүний их эмч, эх баригч мэргэжилтэй. 1992-1998 онд Дорноговь аймгийн Анагаах ухааны коллежид багш, 2005-2009 онд нийслэлийн Эрүүл мэндийн газрын орлогч дарга, 2009-2013 онд Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн өвчин судлалын Үндэсний төвийн даргаар ажиллаж байсан. Тус үндэсний төвийн даргаар ажиллаж байхдаа Жайка-ийн Асбестын шалтгаант уушги тоосжих өвчний талаарх сургалтанд төвийн 9 эмчээ ахлан оролцсон билээ. Уг сургалтанд оролцсоноор байгууллага, хувь хүний цаашлаад улс орны түвшинд ихээхэн амжилтуудыг дагуулсан.

- **Сургалтаар олж авсан мэдлэг, туршлага**

Уушги тоосжих өвчин-Пневмоканиозын төрлүүдийн оношилгооны онолын мэдлэгийг дээшлүүлж, дадлагын сургалтаар тус төвийн эмч нарын рентген, компьютерийн шинжилгээнд ялган оношилох чадамжийг дээшлүүлсэн.

Асбест болон түүний хэрэглээ, хоруу чанар, бие организмд нөлөөлөх нөлөөлөл, үүсэх өвчин, аюулгүй ажиллагааны талаар, асбестын шалтгаан өвчний төрөл, оношилгооны талаар онол мэдлэгтэй болж, асбестын шалтгаант уушги тоосжих өвчний төрлийг оношилох шинжилгээний аргууд, рентген, өндөр нягтралтай компьютерный томографийн зургаар оношилох, ялган оношилгооны

аргачлалыг сурч, чадамжаа дээшлүүлсэн ач холбогдолтой сургалт болсон.

Мөн энэхүү сургалтанд суралцсанаар хувь хүний түвшинд Пневмоканиоз, уушги тоосжих өвчний талаар өөрийн онол практикийн мэдлэг, ур чадвар сайжирсанаар оношилгооны чадамж дээшлэн, Асбестын шалтгаант өвчнийг илрүүлэх, оношлох санаачилга өрнөж, асбесттай өртөж ажиллаж байсан ажиллагсад, өвчтөнүүдийн дунд оношилгооны судалгааг эхлүүлж байсан бол албан байгууллага, ажлын байрны түвшинд сургалтанд хамрагдсан эмч, мэргэжилтнүүд өөрийн байгууллага болон үйлдвэрийн эмч, хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжилтнүүдтэй олсон мэдлэгээ хуваалцан хичээл сургалтыг тогтмол зохион байгуулдаг болж, тэдний оношилгооны чадавхийг дээшлүүлж ажиллаж байна.

Уушги тоосжих өвчин үүсэх эрсдэлтэй үйлдвэр аж ахуйн байгууллагууд болох Бор-Өндөрийн жоншны үйлдвэр, Дулааны II, III цахилгаан станц, Дархан хотын дулааны цахилгаан станц, Хөтөл Цемент шохойн үйлдвэрт хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуйн шинжилгээ, ажиллагсад эрүүл мэндийн тандалт үзлэгийг хийж, уушги тоосжих өвчний 20, асбестоз өвчний 1 тохиолдлыг илрүүлээд байна.

Энэхүү ховор бөгөөд анхны асбестозын тохиолдлын судалгаагаар Шастины нэрэмжит улсын III эмнэлгийн Уушги судлалын тэнхмийн 50 жилийн ойн нэрэмжит олон улсын онол практикийн хуралд дүрс оношлогооны их эмч Д.Болормаа, дотрын эмч Ч.Зулцэцэг нар **“Асбестозын анхны тохиолдлыг эрт үед нь оношлосон нь”** сэдэвт илтгэлээр эрдэм шинжилгээ судалгааны, лекц-өгүүллэгийн, эмнэл зүй-оношлогоо гэсэн 3 төрлөөр оролцон эмнэл зүйн 12 илтгэлээс шалгаран **I байр** эзэлсэн.

Сургалтанд хамрагдсанаар Окаяама хотын Росай эмнэлэгтэй хамтын ажиллагааг өргөжүүлж, Монгол улсын хөдөлмөрийн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, аппарат тоног төхөөрөмжөөр хангах, хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуйг судлах зэрэг олон чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэн ажилласаар байна. Хамтын ажиллагааны үр дүнд 2010 оноос хойш Окаяама хотын Росай эмнэлэгийн дарга асан профессор Нобуёши Шимизу, профессор Тазуми Кишимото, профессор Нобуказу Фужимото болон бусад мэргэжилтнүүд оролцсон, Хөдөлмөрийн эрүүл мэндийн салбар, Эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтнүүдийг хамарсан үндэсний хэмжээний 5 удаагийн онолын болон дадлагын сургалтыг Улаанбаатар хотод-3 удаа, Дархан-Уул аймаг, Багануур дүүргүүдэд зохион зохион байгууллаа. Үндэсний хэмжээний сургалтанд мэргэжлийн өвчин судлаач, үйлдвэрийн, хот, аймаг, дүүргийн төрөлжсөн нарийн мэргэжлийн төв эмнэлгийн эмч, дүрс оношилгооны

эмч мэргэжилтнүүд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны ажилтан, эрүүл ахуйчид зэрэг нийт 700 гаруй хүнийг хамруулан сургасан байна.

Энэхүү хамтын ажиллагааг тасралтгүй үр дүнтэй хөгжүүлэхэд Росай эмнэлгийн дарга асан профессор Нобуёши Шимизу, профессор Тазуми Кишимото, профессор Нобуказу Фужимото, Эрүүл мэнд, спортын дэд сайд Д.Атармаа, ЭМШУИС-ийн НЭС-ийн багш В.Дэлгэрмаа нарын зүтгэл, санаачлагатай ажиллагааны үр дүн юм.

Сургалтаар дамжуулан олж авсан Япон орны талаарх ойлголт

Монгол Японы хооронд дипломат харилцаа 1972 онд тогтож, Монгол улсад ардчилал, зах зээлийн эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжих үеэс эхлэн хоёр орны харилцаа идэвхжиж, эдүгээ олон салбарт хамтын ажиллагаа нь амжилттай өргөжиж байгаа. Энэхүү харилцааны хамгийн үр дүнтэй бөгөөд ач холбогдолоо өгч байгаа нь ЖАЙКА Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага хэрэгжүүлж буй аливаа үйл ажиллагааг гэж ойлгодог. Япон улсад очиж, сургалтанд хамрагдсанаар Анагаах ухааны салбарын өндөр хөгжил, техник тоног төхөөрөмжийн хүчин чадал, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварын түвшин нь үнэхээр өвчний оношийг хөдлөшгүй байдлаар тогоож, эмчилж байгааг нүдээр харж, суралцахад олон зүйлийг бодогдуулж, цаашид сурч, мэдэх, судалж, шинжлэх эрмэлзлэл бий болж, тэдэнтэй хамтран ажиллах сэтгэл өрнөж байсан.

Манай монгол хэлний санд мянга сонсохоор нэг удаа үз гэдэг үгийг санахад үнэхээр өндөр хүчин чадалтай аппарат тоног төхөөрөмжөөр хийсэн шинжилгээ, зургийг, мэргэшсэн мэргэжилтнүүдийн зөвлөмжөөр өвчний эмгэг өөрчлөлтийг бодитоор олж харж, онол практикийн мэдлэгээ дээшлүүлж байгаад, улмаар суралцагсдын ажлын үр дүн бодит болж, ялангуяа Монгол улсын хөдөлмөрийн эрүүл мэндийн салбарын хөгжилд нөлөөлөхүйц үр дүн гарч байгаад Жайка-ийн сургалтанд оролцогчийн хувиар сэтгэл хангалуун явдаг юм.

Баярлалаа

Жайка-ын Сургалт Төгсөгчдийн Монголын Холбоо
Утас: 325939, 311329

E-mail: jicamg-alumni@jica.go.jp

※Мөн шалгаруулалтын хуудас болон бусад холбогдох мэдээллийг доорх линкээр орж авч болно.

www.jaam.mn,

<https://www.facebook.com/JICA-Alumni-Association>



Онол дадлагын сургалтын явц

